



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг шинэчлэх болсонтой холбогдуулан “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 101,009,289 (нэг зуун нэгэн сая есөн мянга хоёр зуун наян есөн) төгрөгийн балансын үнэ, 48,086,644.46 (дөчин найман сая наян зургаан мянга зургаан зуун дөчин дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Р.Буд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



0000557



Төрийн өмчийн бодлого, зохицуулалт
2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр
дугаар тогтоолын хавсралт

м, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаал

Өмчийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл (төгрөгөөр)
Н төлбөр авах йн байр	2007	ш	1	56,009,289.00	56,009,289.00	27,506,784.44	28,502,504.56
Н төлбөр авах йн байр	2011	ш	1	25,000,000.00	25,000,000.00	15,968,750.23	9,031,249.77
Н төлбөр авах йн байр	2010	ш	1	19,999,991.00	19,999,991.00	4,611,109.79	15,388,881.21
			3		101,009,280.00	48,086,644.46	52,922,635.54
ӨНГИЙН ДҮН			2 (гурав)		101,009,289 (нэг зуун нэгэн сая есөн мянга хоёр зуун наян есөн төгрөг)	48,086,644.46 (дөчин найман сая наян зургаан мянга зургаан зуун дөчин дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө)	52,922,635.54 (хоёр сая хоёрхон мянга зургаан зуун дөрвөн төгрөг)